

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН ДАХЬ “ХИЙ” ӨВЧНИЙ ЭМЧИЛГЭЭНИЙ ЖОРОНД  
ХАМГИЙН ОЛОНТОО ХЭРЭГЛЭДЭГ ЭМИЙН ТҮҮХИЙ ЭДҮҮД

Дэлгэрмаа Э<sup>1</sup>, Амбага М<sup>2</sup>, Хүрэлчулуун Б<sup>1</sup>, Болор Б<sup>1</sup>, Базаррагчаа С<sup>3</sup>

<sup>1</sup> “Ач” Анагаах ухаан их сургууль, УАУ-ы тэнхим

<sup>2</sup> Шинэ Анагаах ухаан их сургууль, НСМ-ы тэнхим

<sup>3</sup>Синдүра эмнэлэг

THE MOST FREQUENTLY USED MEDICINAL RAWs FOR THE TREATMENT OF “RLUNG” DIS-  
EASE IN TRADITIONAL MEDICINE

Delgermaa E<sup>1</sup>, Ambaga M<sup>2</sup>, Khurelchuluun B<sup>1</sup>, Bolor B<sup>1</sup>, Bazarragchaa<sup>3</sup>

<sup>1</sup> “Ach” Medical University, Department of Traditional Medicine

<sup>2</sup> “New Medicine” Medical Institute, Department of Newly Coded Medicine

<sup>3</sup>Sindura Hospital

e-mail: delgermaa@ach.edu.mn;

**ABSTRACT**

**Background:** Some findings of an artifacts have revealed that nature based the raw have been used for the treatment of mankind’s diseases over 60 000 years ago. WHO estimates that about 80 percentage of the world’s population are consume the traditional medical care, and uses more than 21,000 plant species for therapeutic purposes. In order to help guide its member countries the World Health Organization (WHO) has developed The WHO Traditional Medicine Strategy 2014–2023. Some of the strategic actions in this document include:

- To develop and share appropriate research methodologies and criteria for evaluating the safety, efficacy, and quality of TM (Traditional Medicine) products;
- To study and explain the disease prevention, health maintenance, the diagnosis and the treatment of the TM disease according to the evidence based scientific studies.

**Objectives:** to determine the most frequently used medicinal plants for the treatment of “Rlung” in the TM.

**Methods:** The comparison method, the synthesis and analysis method, the induction and deduction method, the listing and sorting method, the inspecting and arrange method, and the methods of documents’ drafting were used in this study.

**Results:** It is shown that over 80 raw materials of plant, mineral and animal origins has to list within 32 drug recipes which used “Rlung” disease of TM. The first five raw materials from these 80 ingredients have been repeatedly lists zadi - 30, agar (black, white, red agar) - 19, arur- 19, lish -18, and nin shosh -18 times.

**Conclusion:** The most frequently used the raw materialin the treatment of “Rlung” diseases is the seeds of *Myristica fragrans* Houltt. which contains a lot of the saturated acids with membrane-enhancing effects and strong antioxidant substances

**Keywords:** *Myristica fragrans* Houltt., “Rlung” disease, Traditional Medicine.

**Судалгааны ажлын үндэслэл:** Хүн төрөлхтөн 60 000 жилийн өмнөөс өвчин эмгэгээ эмчлэхдээ ургамал, байгалийн гаралтай эмчилгээг ашигладаг байсан тухай эд өлгийн олдворыг зарим судлаачид илрүүлжээ.<sup>1</sup> ДЭМБ дэлхийн хүн амын 80 орчим хувь нь уламжлалт анагаах ухааны (УАУ)-ы тусламж үйлчилгээг ашигладаг ба эмчилгээний зорилгоор нийтдээ 21000 гаруй ургамлын төрөл зүйлсийг хэрэглэдэг болохыг мэдээлжээ.<sup>2,3</sup> Орчин үеийн уламжлалт анагаах ухаан (ОУАУ)-д хэрэглэж байгаа эмүүдийн 50 - 60%-ийг байгалийн гаралтай ургамал болон түүхий эдээс гарган авсан эмүүд эзэлдэг.<sup>1,2</sup> Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас гаргасан 2014 - 2023 онд “Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх стратеги”-т, “Номхон далайн баруун эргийн уламжлалт анагаах ухааны бүсийн стратеги” (2011-2020)-т зэрэгт<sup>4,5</sup> аюулгүй, үр дүнтэй, чанартай уламжлалт анагаах ухаан (УАУ)-ы бүтээгдэхүүнийг шинжлэх ухааны үүднээс судлаж тайлбарлах зэрэг нь уг судалгааны ажлыг хийх үндэслэл болсон.

**Судалгааны зорилго, зорилт**

УАУ дахь “хий” өвчний эмчилгээнд хамгийн

олонтоо хэрэглэдэг эмийн түүхий эдүүдийг судлах зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

1. УАУ дахь “хий” өвчний эмчилгээнд хэрэглэдэг эмийн бүрэлдэхүүнийг жагсаах;
2. “Хий” өвчний эмчилгээнд хамгийн олон давтамжтай хэрэглэдэг түүхий эдийг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах;

**Судалгааны арга**

Ажиглан-харьцуулах арга, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг онолын судалгааны аргуудыг ашигласан.

**Судалгааны үр дүн**

УАУ-ы “хий” өвчний эмчилгээнд хэрэглэдэг Агар-8 (рангийн, агсааны, лүнгийн, шунгийн, увдисын, догшин Агар-8 зэрэг зургаан зүйл), Агар-11, 15, 20, 25, 35, Агар модон-6, Бармэ хорол, Бурам-15, Галт зэвсэг-12, Гожил-10, Гоньд-8, Зандан манмар, Задь-5, 15, Зүрхний хийн агар, Жавхлант-24, Лиш-25, Хийн өвчний -15, Срогзин -11, 25, Срогзинноров, Сүгмэл-3, Шингүн-5, 25 зэрэг нийт 32 эмийн найрлагыг жагсааж бүртгэсэн.<sup>6,7</sup>

**Table 1.**

***The Medicinal raws which are the most commonly used for the treatment of “Rlung” diseases in the Traditional Medicine***

No	Names of Medicinal Raws (the kind of plant organs)	Frequency
1	M.fragrans (seeds)	30
2	Aquilaria (Aquilaria agallocha, Aquilaria sinensis, Aquilaria Dalbergia odorifera; trees)	19
3	Terminalia chebula (seeds)	19
4	Eugenia Caryophyllato (flower bulb)	18
5	Choerospondias Axillaris (seeds)	18
7	Ferula asafoetida (resin)	15
8	Shachin, Lepus tolai	21



үзүүлдэг гэж үздэг. Түүнээс гадна мономерик болон димерик фенилпропаноидууд, дегидродиизоэуенол, миристицин зэрэг нэгдлүүд нь чөлөөт язгуурыг эсвэл үүссэн хүчилтөрөгчийн идэвхтэй хэлбэрийг шууд саармагжуулах нөлөө үзүүлснээр өөхний хэт исэлдэлтийн бүтээгдэхүүний үүсэлтэнд дарангуйлах нөлөө үзүүлж байгааг нотолсон. Ийнхүү задь нь өөхний хэт ислийг дарангуйлах хүчтэй антиоксидант үйлчилгээтэй болохыг илрүүлсэн гадаадын зарим судлаачдын судалгааны үр дүнгүүд олонтоо байна.<sup>8,9</sup>

### Дүгнэлт

УАУ дахь “хий” өвчний эмчилгээнд хамгийн олон давтамжтай хэрэглэдэг эмийн түүхий эд нь задь байна. Мембран бэхжүүлэх үйлчилгээтэй ханасан хүчил бүхий тос болон хүчтэй антиоксидант үйлчилгээтэй бодисууд ихээр агуулагдсан эмийн түүхий эд задийг “хий” өвчний эмчилгээнд ашигладаг нь тухайн өвчний эмгэг зүйг нотолгоонд суурилсан анагаах ухааны үүднээс тайлбарлах шинэ боломжийг бий болгож байна.

### Номзүй

- 1 1. Sommer JD. The Shanidar IV ‘Flower Burial’: a Re-evaluation of Neanderthal Burial Ritual. Cambridge Archaeological Journal. April 1999;9(01):127-129
- 2 2. Traditional and Complementary Medicine Policy. In MDS-3: Managing Access to Medicines and Health Technologies, Chapter 5. Arlington: WHO. 2012. p. 5.1-5.5.
- 3 3. Modak M, Dixit P, Londhe J, Ghaskadbi S et al. Indian Herbs and Herbal Drugs Used for the Treatment of Diabetes. J Clin Biochem. Nutr. 2007;40:163–173.
- 4 4. WHO Traditional Medicine Strategy 2014 –2023. Geneva: WHO; 2013.
- 5 5. Номхон далайн баруун эргийн уламжлалт анагаах ухааны бүсийн

стратеги. (2011-2020) ДЭМБ Номхон далайн баруун эргийн бүс. 2010. х.16-25

- 6 6. Чойжамц (төвөд хэлнээс орчуулсан Д.Балгансүрэн). Маш гайхамшигт хуримын сан. Улаанбаатар, Армийн хэвлэх үйлдвэр. 1991. х. 115-116, 139-141.
- 7 7. Амбага М, Саранцэцэг Б, Болд Ш. Дан ба нийлмэл уламжлалт эмийн жагсаалт, тэдгээрийн зохистой хэрэглээ. Улаанбаатар, 1999. х. 1-14.
- 8 8. Jaiswal P, Kumar P, Singh VK, Singh DK., Biological Effects of Myristica fragrans. Annu Rev Biomed Sci. 2009;11:21-29.
- 9 9. The Ayurvedic pharmacopoeia of India. 1st ed. Part I, Volume I. Delhi: Civil lines; 2001. p. 43, 49- 50, 53-54, 103

Уншин танилцаж,  
 нийтлэх санал өгсөн:  
 Академич, АШУ-ы доктор, профессор  
 Ш.Болд